



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар Б/11

Зуунмод

Г.Ариун-Уянгаар албан үүргийг
түр орлон гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 42 дугаар зүйлийн 42.1.6, 43 дугаар зүйлийн 43.3.4, 57 дугаар зүйлийн 57.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь заалтууд, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", мөн 2022 оны 491 дүгээр тогтоолоор баталсан "Журамд өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 2, 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3, 2023 оны 312 дугаар тогтоолоор баталсан "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 1, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 526 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" тогтоолын 1.3, аймгийн Засаг даргын 2023 оны А/758 дугаар захирамжаар баталсан "Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм, бүтэц орон тоог батлах тухай" захирамжийн 2 дугаар хавсралт, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны Б/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ширмэнгийн Мөнхзулыг хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд албан тушаалыг Ганзоригийн Ариун-Уянгаар 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Г.Ариун-Уянгын албан тушаалын сарын үндсэн цалинг ТЗ-9 зэрэглэл 1,100,000 (Нэг сая нэг зуун мянга) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 8 хувиар, орон нутагт ажилласан нэмэгдлийг улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн төсвөөс 50 хувиар тооцож 2024 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажил хүлээлцүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Ахлах мэргэжилтэн (А.Зоригоо)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНХУЯГ





**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар Б/12

Зуунмод сум

Ажилд томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2023 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 312 дугаар тогтоол, 2023 оны 240 дугаар тогтоол "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай"-ын 6 дугаар хавсралт, 2023 оны 241 дүгээр тогтоол "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-ын 10 дугаар хавсралт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр 20-ны өдрийн А/758 дугаар захирамж, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны А/03 тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын нягтлан бодогчоор Батзоригтын Бямбасүрэнг 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Бямбасүрэнгийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТҮ-8 зэрэглэл 1,114,000 (Нэг сая нэг зуун арван дөрвөн мянга) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг 8 хувиар тогтоосугай.

3. Б.Бямбасүрэнгийн албан тушаалын үндсэн цалин, нэмэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б. ГАНХУЯГ



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар Б/13

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 38.1.9, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн (шинэчилсэн найруулга) 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.1.8, Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/758 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 2.4, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архив, бичиг хэргийн ажилтан Т.Ууганбаярыг Архивын Ерөнхий Газраас зохион байгуулсан мэргэшүүлэх 1 сарын сургалтанд хамруулсугай.
2. Сургалтын төлбөр 250.000 (Хоёр зуун тавин мянга) төгрөгийг зохих зардлаас гаргахыг (Б.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНХУЯГ

